




ОЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байх газар, газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч болохыг тодруулан хуульчилсан. Төрийн нийтийн өмч болох ойн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх харилцааг зохицуулж буй хууль, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага үүсээд байна.

Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах дараахь хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна. Үүнд:

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн “Ногоон хөгжил”-ийн зорилтод “Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулна.” гэж заасан.

Энэхүү зорилтын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 6.1.3-т “ой зохион байгуулалтыг тогтмол явуулж, ойн экосистемийн нөөц, төлөв байдлыг үнэлнэ”, 6.2.3-т “ашиглалтад өртөмтгий амьтан, ургамлыг зориудаар өсгөн үржүүлэх, тарималжуулах, агро-ойн парк байгуулж, ашиглалтын нөөцийг бүсчлэн бий болгож байгалиас шууд авч ашиглах дарамтыг бууруулна” мөн 6.2.4-т “ойжуулах, ойн тэлэн ургалтыг дэмжих, нөхөн сэргээх, ой хамгааллын арга хэмжээ авах замаар ойн хомсдолоос сэргийлэн, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нийт газар нутгийн 9 хувьд хүргэж, нүүрсхүчлийн хийн шингээлтийг нэмэгдүүлнэ.” гэж тус тус заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 6.2.5-д “ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ”, 6.4.4-т “хүлэмжийн хийн ялгарлыг 12.3 хувиар бууруулна”, мөн оны “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 24 дүгээр тогтоолын хавсралтын 5.1.5-д “Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг 8.6 хувь хүргэж, мод тарьж

ногоон хөгжилд хувь нэмэр оруулсан иргэд, аж ахуйн нэгжид мөнгөн урамшуулал олгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэж тус тус тусгажээ.

Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад заасны дагуу Ойн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай болохыг тодорхойлсон болно.

1.2.Практик шаардлага

2021 онд Ойн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр төрийн захиргааны төв байгууллагын дийлэнх бүрэн эрх нь яамны эрхлэх асуудалд хамаарахгүй, ойг үржүүлэх, нөхөн сэргээх, ойжуулах ажлын суурь нөхцөл болсон модлог ургамлын үр, үржлийн материал бэлтгэх, үрийн чанар, хяналт бодлого, зохицуулалтгүй, ойн мэргэжлийн байгууллагын эрх олгох төрийн үйлчилгээ чирэгдэлгүй, хүртээмжтэй байх зарчимд нийцэхгүй, ойн дагалт баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах харилцаанд мөрдөх хууль тогтоомж тодорхой бус зэрэг дүгнэлт гарсан байна.

Төрийн захиргааны төв байгууллага нь Ойн тухай хуулийн дагуу 34 тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлж байгаагаас 24 хувь нь бодлого боловсруулах, зохицуулах эрх хэмжээнд, 76 хувь нь зохион байгуулах, хяналт шинжилгээ, үнэлгээ, үйлчилгээ, санхүүжилтийн эрх хэмжээнд хамаарч байна. Ойн тухай хуульд тусгагдсан төрийн захиргааны төв байгууллагын тодорхой бүрэн эрхийн зөвхөн 33 хувь нь яамны эрхлэх нийтлэг эрх болох талаар үнэлгээний тайланд тусгагджээ.

Биологи хийгээд сортын шинжийг хадгалсан модлог ургамлын үр, үржлийн материал бэлтгэх, сайн чанарын үрээр ойн үрийн нөөцийн сан бүрдүүлэх зэрэг ойн үрийн талаарх бодлого, зохицуулалт өнөөг хүртэл Ойн тухай хуульд тусгагдаагүй явж иржээ. Иймд модлог ургамлын үр, үржлийн материалын үйлдвэрлэлд төрийн дэмжлэг, зохицуулалт шаардлагатай байна.

Төрийн захиргааны төв байгууллагаас олгож байгаа ойн мэргэжлийн байгууллагын эрхийг иргэн, хуулийн этгээд хуулиар хориглоогүй ажил, үйлчилгээг чөлөөтэй эрхлэх, төрийн байгууллага, албан тушаалтнаас олгох эрх, лицензийн тоог бууруулах, төрийн ажил үйлчилгээ хүндрэлгүй, шуурхай, хүртээмжтэй байх бодлого зарчимд нийцүүлэн магадлан итгэмжлэлийн тогтолцоонд шилжүүлж шинэчлэх нь шаардлага үүсээд байна.

Түүнчлэн хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу улсын хилийн шугам дайран гарсан ойд улсын хилийн зурвас гаргах, сэргээхтэй холбоотой үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох шаардлага байна.

Ойн салбарын ажилтнуудаас авсан санал асуулгаар оролцогчдын 57 хувь нь ойн үр, 52 хувь нь мод үржүүлэг, 30 хувь нь ойн дагалт баялгийг ашиглах, хамгаалах зохицуулалт хангалтгүй, хэрэгждэггүй талаар судалгаанд тусгагджээ. Ойг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглахад судалгаанд оролцогчдын 65 хувь нь ойн үр бэлтгэх, ойн үрийн нөөц бүрдүүлэх, 50 хувь нь ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага бий болгох, 44 хувь нь ойн мэргэжлийн байгууллагыг дэмжих арга хэмжээг нэн тэргүүнд авах шаардлагатай хэмээн үзсэн болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлигаар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг санаачлан өрнүүлж, ойн салбарын бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах төрийн захиргааны байгууллага болох Ойн агентлаг болон төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан засаглал, үр нөлөөтэй удирдлагын тогтолцоо бүхий ойн аж ахуйн нэгжийг байгуулж, санхүүгийн зохистой механизмыг бүрдүүлэх, агро-ойг хөгжүүлэх, мод тарьж ургуулах орчин үеийн техник технологийг нэвтрүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосон. Зарлигийн хэрэгжилтийг хангахад улсын хэмжээний нэгдсэн зохицуулалт, төлөвлөлт, арга технологиор хангах, ойн хууль, тогтоомжийг сайжруулах бодит нөхцөл үүсээд байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь 7 зүйлтэй байхаар боловсруулагдана. Хуулийн төслөөр ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын эрх зүйн үндсийг бүрдүүлэх, бүрэн эрхийг тодорхойлох, ойн үрийн талаарх бодлого, зохицуулалтыг тусгах, мэргэжлийн байгууллагын эрх олгох тогтолцооноос магадлан итгэмжлэлийн тогтолцоонд шилжүүлж төрийн ажил үйлчилгээ хүндрэлгүй, шуурхай, хүртээмжтэй байх бодлого зарчимд нийцүүлэх зорилготой.

Хуулийн төсөлд модлог ургамлын үр, үржлийн материал, ойн байгууллагын магадлан итгэмжлэл зэрэг ойлголтын хуулийн нэр томъёоны тодорхойлолтыг шинээр тусгаж, мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрийн бодлого, зохицуулалтын харилцаан дахь хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийг тодорхойлохоос гадна, ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, ойн аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх бүрэн эрхийг тусгана.

Түүнчлэн модлог ургамлын үр, үржлийн материал бэлтгэх харилцааг зохицуулах зүйлийг шинээр тусгахаас гадна ойн мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлагыг тогтоож, журмаар нарийвчлан зохицуулах шаардлагатай харилцааг тодорхойлж, захиргааны хэм хэмжээний акт гаргах эрхийг ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад олгох зохицуулалтыг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн ойн сайн засаглалыг дэмжих, бэхжүүлэх, ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх боломж нөхцөл бүрдэнэ.

Төрийн нийтийн өмч болох ойн нөөцийг нэмэгдүүлэх, ойн эрүүл ахуй, амьдрах чадвар, бүтээмж, экологи, эдийн засаг, нийгмийн үр ашгийг сайжруулах нь Монгол Улсын одоо ба ирээдүй үеийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг хангахад ач холбогдолтой.

Мөн ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дотоод бүтэц дэх Ойн бодлого зохицуулалтын газар болон Ойн судалгаа хөгжлийн төвд ажиллаж байгаа орон тооны дийлэнх хэсгийг шинээр байгуулагдах бүтцэд шилжүүлж, төсөвт дарамт үүсгэхгүйгээр батлагдсан төсөвт багтаан сэргээн байгуулна.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаар

Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Биологийн төрөл зүйлийн тухай конвенц, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенц, Цөлжилттэй тэмцэх конвенц зэрэг Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцсэн болно. Уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль байхгүй болно.